

БАТЛАВ.  
ЦДҮС ТӨХК-ИЙН  
ГОВИЙН БҮСИЙН САЛБАРЫН ЕРӨНХИЙ  
ИНЖЕНЕР М.ЭНХСОД



БАТЛАВ.  
БЗӨБЦТС ТӨХК-ИЙН  
ТУАХ ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
ИНЖЕНЕР М.ОТГОНБААТАР



**ЦДҮС ТӨХК-ИЙН ГОВИЙН БҮСИЙН САЛБАРЫН БОЛОН БЗӨБЦТС  
ТӨХК-ИЙН ШУУРХАЙ АЖИЛЛАГААНЫ ХҮМҮҮСИЙН ХАРЬЦААНЫ  
ЗААВАР**

**ЗААВРЫГ МЭДВЭЛ ЗОХИХ ХҮМҮҮС**

1. ЦДҮС ТӨХК-ИЙН ГОВИЙН БҮСИЙН САЛБАРЫН УДИРДЛАГА, ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛТАН НАР
2. ЦДҮС ТӨХК-ИЙН ГОВИЙН БҮСИЙН САЛБАРЫН ШУУРХАЙ АЖИЛЛАГААНЫ БҮХ АЖИЛЛАГСАД
3. БЗӨБЦТС ТӨХК-ИЙН УДИРДЛАГА, ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛТАН НАР
4. БЗӨБЦТС ТӨХК БОЛОН ДУНДГОВЬ ЦТССАЛБАРЫН ШУУРХАЙ АЖИЛЛАГААНЫ БҮХ АЖИЛЛАГСАД

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Энэхүү харьцааны зааврын зорилго нь хоёр байгууллагын хооронд сэлгэн залгалт хийх журам, цахилгаан тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааны ашиглалт үйлчилгээ, бүрэн бүтэн байдал, найдвартай горим ажиллагаа, цахилгаан байгууламжийн засвар үйлчилгээний ажлын аюулгүй байдлыг хангах, аваарийн үеийн тасралт, сэлгэн залгалт, шуурхай ажиллагааны харилцааг зохицуулахад оршино.

1.2 Шуурхай ажиллагааны хүмүүс хоорондын харьцаандаа Монгол Улсын Эрчим хүчний тухай хууль, Нэгдсэн сүлжээний дүрэм, Нэгдсэн сүлжээнд гарсан аваари устгах, цахилгаан хуваарилах байгууламжинд сэлгэн залгалт хийх зааврын эмхэтгэл, ЦЭХ хэрэглэх дүрэм, ХМС,ТАД, ААД болон бусад удирдамж заавруудыг мөрдлөг болгоно.

1.3 Хоёр байгууллагын шуурхай ажиллагааны хүмүүсийн харьцааны талаар энэхүү зааварт тусгагдаагүй, зохицуулах боломжгүй нөхцөл байдал үүсвэл уг зааврын 1.2-р заалтыг мөрдлөг болгоно.

1.4 Энэхүү зааврыг батлагдсан өдрөөс эхлэн мөрдөх ба 2 жилийн хугацаанд хүчинтэй байна.

1.5 Зааврын хүчинтэй хугацаа дуусахаас өмнө зааварт нэмэлт болон өөрчлөлт оруулах саналтай бол уг хүсэлтээ 2 тал харилцан бичгээр хүргүүлнэ.

1.6 Зааварт нэмэлт болон өөрчлөлт оруулах талаар аль нэг тал хүсэлт гаргаагүй бол харьцааны зааврын хүчинтэй байх хугацаагаар сунгасанд тооцно.

1.7 ЭХ-ний салбарт мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журам, заавруудын зөрчлийг 2 талын удирдлага арилгах арга хэмжээ авах ба гэм буруутан, хохирлын хэмжээг тогтоох, төлбөр хариуцах эзнийг тодорхойлохоор 2 тал хамтарсан комисс томилон ажлын 5 өдрийн дотор акт тогтоож баталгаажуулна.

1.8 Хоёр байгууллагын цахилгаан тоног төхөөрөмжийн эзэмшлийн заагийг энэхүү зааврын Хавсралт № 1-ээр баталгаажуулав.

### **ХОЁР. ШУУРХАЙ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ БА СЭЛГЭН ЗАЛГАЛТ ХИЙХ**

2.1 “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбар болон “БЗӨБЦТС” ХК нь жил бүрийн 02 дугаар сарын 01-ний дотор өөрийн компанийн Шуурхай ажиллагаа явуулах эрх бүхий хүмүүсийн нэрсийг, жил бүрийн 04 сарын 01-ний дотор аюулгүй ажиллагаа хариуцагч нарын нэрсийг шинэчлэн гаргаж, тус бүрийн ерөнхий инженерээр батлуулан солилцоно. Хоёр тал уг жагсаалтанд өөрчлөлт орсон үед зөвхөн албан бичиг болон телефонограммаар мэдэгдэнэ

2.2 Хоёр байгууллагын шуурхай ажиллагааны удирдлагууд шугам, дэд станц, тоног төхөөрөмжийн шуурхай ажиллагааны нэр хаягийг “Нэгдсэн сүлжээний дүрэм”-д заасны дагуу жил бүр тулган баталгаажуулж байна.

2.3 Хоёр талын диспетчерийн хооронд явагдах шуурхай ажиллагааг тус бүрийн ерөнхий инженерийн баталсан шуурхай ажиллагаанд оролцох эрх бүхий хүмүүс явуулах ёстой.

2.4 Шуурхай ажиллагаа нь БЗӨБЦТС ХК-ийн болон Дундговь ЦТССалбарын ээлжийн инженерүүд, ЦДҮС ТӨХК-ийн болон Зүүн Өмнөд Бүсийн, Говийн Бүсийн ээлжийн инженерүүдийн хооронд явагдана.

2.5 Шуурхай ажиллагааны хүмүүс нь диспетчерийн шуурхай холбоогоор харилцахдаа эхлээд өөрийн байгууллагын нэр, дараа нь өөрийн албан тушаал, нэрийг заавал хэлж, харилцагч хүнийхээ албан тушаал, нэрийг мэдсэний дараа албан ёсны яриаг эхлүүлнэ.

2.6 Шуурхай ажиллагааны яриа нь товч тодорхой техникийн хэл яриагаар үнэн зөв явагдах ба хоёр байгууллагын диспетчерийн шуурхай ажиллагааны журналд тодорхой, үнэн зөв, бүрэн гүйцэд тэмдэглэгдсэн байх ёстой. Хоёр байгууллагын диспетчер нь шуурхай яриа үнэн зөв явагдсан эсэхийг шалгаж, хянах зорилгоор бие биенээсээ давтан асууж болно.

2.7 Хоёр байгууллагын диспетчерийн хооронд явагдсан бүх яриа нь “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбарын диспетчер болон “БЗӨБЦТС” ХК-ийн диспетчерүүдийн шуурхай ажиллагааны яриа видео, дуу бичлэгийн төхөөрөмжинд байнга бичигдэж байх бөгөөд хоёр тал уг төхөөрөмжүүдийнхээ ажиллагааны бэлэн байдлыг хангаж ажиллана.

2.8 Шуурхай ажиллагааны ярианд ойлгомжгүй болон маргаантай зүйл гарсан тохиолдолд хоёр талын комисс хамтран хоёр байгууллагын шуурхай ажиллагааны журналын тэмдэглэл, дуу бичлэгийг сонсож, дүгнэлт гаргана.

2.9 Аваари саатал, тасралтын үед 2 байгууллагын тухайн үед ээлжинд гарч байгаа диспетчерүүд шуурхай ажиллагааг гардан явуулах бөгөөд 2 байгууллагын захирал болон техникийн дээд удирдлагууд аваари устгах ажиллагааг зайлшгүй үед биечлэн удирдахаас бусад тохиолдолд шуурхай ажиллагаанд шууд оролцохыг хориглоно.

2.10 “ЦДҮС”ХК-ийн Говийн Бүсийн Салбарын дэд станцуудын шинээс шууд тэжээгддэг “БЗӨБЦТС”ХК-тай гэрээтэй ажилладаг хэрэглэгчтэй шуурхай ажиллагаа явуулахдаа зөвхөн “БЗӨБЦТС”ХК болон Дундговь ЦТССалбарын диспетчерээр дамжуулан харьцана. Үүнд: “ЦДҮС”ХК-ийн Говийн Бүсийн Салбартай аж ахуйн гэрээтэй ажилладаг байгууллагууд хамаарахгүй.

2.11 “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбарын диспетчер нь осол аваари, гэмтэл, галын аюул гарах болон эдгээрээс урьдчилан сэргийлэх, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор тоноглолд таслалт, залгалт хийх зайлшгүй шаардлагатай үед хэний мэдлийн тоноглолоос үл хамааран урьдчилан мэдэгдэлгүйгээр сэлгэн залгалт хийх бөгөөд үүний дараа уг хийсэн үйлдлийн талаарх мэдээллээ “БЗӨБЦТС” ХК-ийн болон Дундговь ЦТССалбарын диспетчерт өгнө.

2.12 Хоёр байгууллагын диспетчерүүд нь Шуурхай ажиллагаа болон ТАД, ААД зөрчигдсөн үед холбогдох байгууллагын техникийн удирдлагад мэдээлж өөрөө болон доод тушаалын хүмүүсээр зөрчлийг арилгуулах эрхтэй.

2.13 Хоёр байгууллагын шуурхай ажиллагааны хүмүүс нь доор дурьдсан тохиолдлуудад мэдээллийг харилцан шуурхай мэдээлнэ. Үүнд:

- » Аваари осол гарах, байгалийн давагдашгүй хүчин зүйлээс хамааралтай онцгой байдал гарах
- » ТАД, ААД зөрчигдөх
- » Тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа алдагдах
- » Хүчдэл, давтамжийн гүнзгий өөрчлөлт гарах
- » Тоолуурын заалт авах
- » Цахилгаан тоног төхөөрөмж гэмтэх, тасралт саатал гарах
- » Шинээр холбогдож байгаа шугам, дэд станцын талаархи мэдээлэл
- » Шугам, тоноглолд сэлгэн залгалт хийх

2.14 “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбар болон “БЗӨБЦТС” ХК-ийн хооронд хийгдэх сэлгэн залгалт болон шуурхай ажиллагааны асуудлаар хоёр талын диспетчер санал зөрвөл бие биенээс тайлбар шаардах, өөрийн саналыг батлах эрхтэй. Саналыг хүлээж аваагүй буюу өөрийн шийдвэр, мэдээллийг зөв гэж үзвэл хоёр талын диспетчер нь “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбарын болон “БЗӨБЦТС” ХК-ийн шуурхай ажиллагааны дээд удирдлагад уг асуудлыг тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.

2.15 Хэрэв шийдвэр өгсөн шуурхай ажиллагааны хүн нь өөрийн шийдвэр, мэдээллийг үнэн зөв болохыг нотолбол хоёр талын шуурхай ажиллагааны журналд энэ тухай тэмдэглэл хийж, шийвэрийг биелүүлэх бөгөөд энэ тохиолдолд бүх хариуцлагыг шийдвэр болон мэдээлэл өгсөн хүн хүлээнэ.

2.16 ЦЭХ-ний хэрэглээг тооцож байхын тулд хэмжих хэрэгсэл ба тооцооны тоолуурын заалтыг харилцан авч байна.

2.17 Шуурхай ажиллагааны холбоо тасарсан үед нөгөө талынхаа шуурхай ажиллагааны холбоог ашиглан мэдээ, мэдээллийг дамжуулж болно. Энэ тохиолдолд дамжуулсан мэдээ мэдээлэл, мэдээлэл хүлээн авсан болон дамжуулсан хүний албан тушаал нэр, цаг минутыг хоёр талын шуурхай ажиллагааны журналд заавал тэмдэглэсэн байна.

2.18 “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбарын болон “БЗӨБЦТС” ХК-ийн хооронд явагдаж байгаа шуурхай ажиллагааг үндэслэлгүйгээр удаашруулсан буюу удаашрахад нөлөөлсөн шуурхай ажиллагааны болон удирдах ажилтан зохих хариуцлага хүлээнэ.

## **ГУРАВ: ЦАХИЛГААН ТОНОГЛОЛЫГ ЗАСВАРТ ГАРГАХ БА ЗАХИАЛГА ҮЙЛДЭХ**

3.1. “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбар болон “БЗӨБЦТС” ХК-нь тухайн сард таслагдах тоноглолын таслалтын графикийг өмнөх сарын 25-ны дотор бүрэн гаргаж, өөрсдийн ерөнхий инженерээр батлуулан хоорондоо солилцох ба графикийн зохицуулалтыг хийнэ. Уг зохицуулалтыг хийхдээ дараахь зарчмыг баримтлана. Үүнд:

- » Хэрэглэгчийн схемийн найдваржилтыг алдагдуулахгүй байх горимыг сонгож ажиллуулах.

- » Хоёр байгууллагын хувьд хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг зайлшгүй тасалдуулж гүйцэтгэх ажил байвал ажил гүйцэтгэх хугацааг давхцуулах, ЦЭХ-ний дутуу түгээлтийг аль болохоор бага байхаар зохион байгуулах
- » Хоёр байгууллагын аль нэг талын шугам, тоноглолыг засварт гаргахад цахилгаан эрчим хүч хэрэглэгчдийн хэвийн үйл ажиллагаанд хүндрэл учруулахаар бол уг засварын хугацааг аль болох багасгах, өөрчлөх зорилгоор хоёр тал хамтран ярилцаж зохицуулалт хийнэ

3.2. “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбарын дэд станцуудын шинээс шууд тэжээгддэг боловч “БЗӨБЦТС” ХК болон бусад хэрэглэгчид уг шугам, тоноглолыг хамтран эзэмшиж байвал өөрийн шугам, тоноглолыг засварт гаргах захиалгаа БЗӨБЦТС ХК-ийн диспетчерээр дамжуулан ЦДҮС ХК-ийн Говийн Бүсийн Салбарын диспетчерт өгнө. Үүнд: “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбартай аж ахуйн гэрээтэй ажилладаг байгууллагууд хамаарахгүй.

3.3. Хоёр байгууллага нь өөрийн эзэмшлийн тоноглолуудыг засварт гаргах, батлагдсан горимд өөрчлөлт оруулахаар бол гүйцэтгэх ажлын захиалгаа өөрийн байгууллагын техникийн дээд удирдлагаар батлуулсаны дараа дараахь тохиолдлуудад нөгөө талын диспетчерт өгнө. Үүнд:

- » Шугам, тоноглолыг засварт гаргаж ажилд орох үед нөгөө байгууллагын эзэмшлийн тоноглолд ААД-нд заасны дагуу техникийн арга хэмжээ авах шаардлагатай үед
- » Шугам, тоноглолыг засварт гаргах, ажлын байр бэлдэх сэлгэн залгалт хийх явцдаа нөгөө байгууллагын эзэмшлийн шугам, тоноглолын ажиллагааг аваарийн горимын их ачааллаас хэтрүүлэхээр бол

3.4. “БЗӨБЦТС” ХК нь шугам, тоноглолын засварын ажлын явцад “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбарын эзэмшлийн хүрээнд орж ажил гүйцэтгэх үед ажилд орох захиалгаа “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбарын диспетчерт өгнө. /Жишээ нь: Дэд станцын ХХБ-нд орж кабелийн үзүүр тайлах, уях гэх мэт./

3.5. Хоёр байгууллага нь ажлын жирийн өдрүүдэд хийгдэх ажлын захиалгыг 1 хоногийн өмнө Бямба, Ням, Даваа гаригуудад хийх ажлын захиалгыг Баасан гаригт, баяр ёслолын өдрүүдэд хийгдэх ажлын захиалгыг 3 хоногийн өмнө, олон үйлдэлт ажлын захиалгыг 3 хоногийн өмнө 11 цаг 00 минутаас өмнө нөгөө талын диспетчерт өгнө.

3.6. Захиалга хүлээн авсан диспетчер нь уг ажлын захиалга батлагдсан эсэх тухай мэдээллийг тухайн өдрийн 15 цаг 00 минутаас өмнө нөгөө талын диспетчерт албан ёсоор мэдэгдэж, шуурхай ажиллагааны журналд тэмдэглэнэ.

3.7. “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбарын диспетчер нь өөрийн төлөвлөгөөт ажлын батлагдсан захиалгыг Монгол улсын эрчим хүчний хуулийн 29.1.2 заалтын дагуу “БЗӨБЦТС” ХК-ийн диспетчерт ажил хийгдэхээс 1-3 хоногийн өмнө мэдэгдэнэ.

3.8. Цахилгаан тоноглол, шугаманд гарсан аварийг устгах зорилгоор тоноглол болон шугамыг засварт гаргах аварийн захиалгыг хоёр байгууллагын диспетчер хоногийн ямар ч үед харилцан өгнө.

3.9. Батлагдаж зөвшөөрсөн захиалгын дагуу “БЗӨБЦТС” ХК-ийн диспетчерүүд хэрэглэгчдэд Монгол Улсын Эрчим Хүчний тухай хуулийн 29.1.2-д заасны дагуу цахилгаан эрчим хүчээр таслах болсон тухай зарлал хийнэ. Зарлал хийсэн хариуцлагыг “БЗӨБЦТС” ХК-ийн зарлал хийсэн диспетчер бүрэн хүлээнэ. Үүнд “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбартай аж ахуйн гэрээтэй ажилладаг байгууллагууд хамаарахгүй.

3.10. “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбар нь “БЗӨБЦТС” ХК-ийн зарлал хийсэн диспетчерүүдээр зарлал хийлгээд батлагдсан захиалгат ажилд ороогүй буюу хойшлуулах болсон тохиолдолд хэрэглэгчээс тавьсан санал гомдол, шаардлагыг биелүүлэх ба дутуу түгээсэн цахилгаан эрчим хүчний тооцоог хийж хариуцлагыг бүрэн хүлээнэ. Үүнд “ Цаг агаарын таагүй нөхцөлөөс шалтгаалсан тохиолдолд хамаарахгүй ”

3.11. Хийгдэж байгаа захиалгат ажлын явцын талаархи мэдээллийг 2 байгууллагын диспетчерүүд харилцан солилцоно.

#### ДӨРӨВ. АВААРИ УСТГАХ

4.1 Хоёр байгууллагын шуурхай ажиллагааны хүмүүс нь тасралт, саатал, аваари гарсан үед мэдээллийг шуурхай үнэн зөв солилцож, харилцан нягт уялдаатай ажиллана.

4.2 “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн салбарын дэд станцын диспетчерүүд болон “БЗӨБЦТС” ХК-ийн диспетчерүүд нь дамжуулах ба түгээх сүлжээнд гарсан тасралтын талаархи бүрэн мэдээллийг харилцан мэдээлнэ.

4.3 “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбарын дэд станцуудын диспетчер нь цахилгаан дамжуулах шугам хамгаалалтаар тасраад АПВ-ийн цикл яваад нэг удаа амжилтгүй тохиолдолд БЗӨБЦТС ХК-ийн диспетчерт мэдэгдэж нэг удаа залгаж үзэх арга хэмжээ авна.

4.4 Хоёр талын диспетчерүүд нь тасралт гарсан үед ямар хамгаалалтаар шугам тасарсан мэдээллийг тухайн цаг үед нь өгөөд, аваари саатлыг устгаж хэвийн горим схемд оруулсаны дараа тасралтын шалтгаан, тухайн шугамын параметрууд, горим схем өөрчлөгдсөн байдал, тасалсан, залгасан цагийг тулгаж, мэдээлэл заавал солилцсон байна. Тасралтын талаар мэдээлэл буруу өгсөн, шуурхай ажиллагааг удаашируулсан, мэдээлэл хийхээс татгалзсан ажилтанг өөр өөрийн техникийн дээд удирдлагуудад мэдэгдэж хариуцлага тооцуулна.

4.5 “БЗӨБЦТС” ХК-ийн диспетчер нь өөрийн эзэмшилд байдаг боловч “ ЦДҮС ” ХК-ийн дэд станцуудтай холбогдсон шугам тоноглол тасарсан үед “ ЦДҮС ” ХК-ийн Говийн Бүсийн Салбарын диспетчертэй холбоо барилгүй уг шугам тоноглолд сэлгэн залгалт хийхийг ХОРИГЛОНО.

4.6 “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн салбарын диспетчер нь өөрийн эзэмшилд боловч “БЗӨБЦТС” ХК-ийн хэрэглэгчийн эзэмшилд байдаг 6, 10, 35кВ шугаманд гэмтэл гарсан тохиолдолд гэмтлийг тусгаарлан, арилгуулах талаар “БЗӨБЦТС” ХК-ийн диспетчерт шуурхай мэдээлэл хийх ба шаардлагатай үед нь ажлын байр бэлдэж өгнө.

4.7 “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн салбарын диспетчер нь тасралтын мөрөөр илэрсэн гэмтлийг бүрэн тодорхойлж устгасан тухай “БЗӨБЦТС” ХК-ний диспетчерийн мэдээллийг үндэслэн уг шугамыг хүчдэлд залгаж, энэ талаархи мэдээллийг шуурхай ажиллагааны журналд тэмдэглэнэ.

4.8 Шуурхай ажиллагааны хүмүүс хүчдэл гэнэт тасраад урьдчилан мэдэгдэлгүй ирж болдогыг ямагт санаж ажиллана. Хүчдэл тасарсан үед ямар нэгэн ажил, үзлэг, сэлгэн залгалтын үйлдэл гүйцэтгэхийг ХОРИГЛОНО.

4.9 Шуурхай ажиллагааны хүмүүс нь аваари саатал, тасралт гарсан үед шугам, тоноглол дээр ажиллах үеийн аюулгүй ажиллагааг хангах техникийн арга хэмжээг аваагүй, ийм арга хэмжээ авахаар төлөвлөж байсан боловч Аюулгүй ажиллагааг хангах техникийн арга хэмжээ авагдсан талаар бүрэн мэдээлэл өгөөгүй бол уг шугам тоноглолыг ХҮЧДЭЛТЭЙ ГЭЖ ТООЦОЖ ажиллана.

### **ТАВ. ГОРИМ АЖИЛЛАГАА, ТАСЛАЛТ ХЯЗГААРЛАЛТЫН ТУХАЙ**

5.1 “БЗӨБЦТС” ХК нь хэрэглэгчдийнхээ авах хэвийн горимын үеийн болон аваарийн горимын үеийн их ачааллын хэмжээг жил бүрийн өвөл, зуны горимын ажиллагаанд шилжихээс өмнө буюу 03-р сарын 15 болон 08-р сарын 15-нд шинэчлэн баталгаажуулж “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбарт албан бичгээр ирүүлнэ.

5.2 “БЗӨБЦТС” ХК нь “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн салбарын дэд станцуудаас хэрэглэгч холбох тохиолдолд “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбараас албан ёсоор зөвшөөрөл авна.

5.3 Хоёр байгууллага нь жил бүрийн 03 дугаар сарын 01-ний өдөр өөрийн компанийн шуурхай ажиллагааны схемийн өөрчлөлтийг харилцан солилцож байна.

5.4 “БЗӨБЦТС” ХК нь “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбарын харъяа дэд станц болон өөрийн харъяа дэд станцуудын шинээс гарч байгаа 35,15,10,6кВ-ын шугам, дэд станцуудын реле хамгаалалтын тавилын тооцоог хийж, ДҮТ-ээр баталгаажуулан уг шугам, дэд станцын талаархи бүрэн мэдээллийг комисс ажиллахаас ажлын 5 өдрийн өмнө албан бичгээр мэдэгдэнэ.

5.5 “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбарын харъяа дэд станцуудаас гарсан 35, 15, 10, 6 кВ шугамуудын РХА болон АЧР-ийн тавил, тооцоог “БЗӨБЦТС” ХК хийж, ДҮТ-ээр баталгаажуулах ба тавилыг “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн салбар тавих ба “БЗӨБЦТС” ХК-ийн РХА-ны инженер заавал байлцаж, хяналт тавина.

5.6 “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн харъяа дэд станцуудын шин болон хуучин шугамын дундаас отбайк авч шинээр холбогдож байгаа “БЗӨБЦТС” ХК-ийн 35/15/10/6кВ-ын шугам, дэд өртөө, дэд станцын техникийн бичиг баримт, ачаалалын өгөгдлийг техникийн удирдлагад ирүүлээгүй бол туршилтын хүчдэлд залгах захиалгыг хүлээж авахгүй.

5.7 “ЦДҮС”-ХК-ийн Говийн Бүсийн Салбарын дэд станцын диспетчерүүд нь “БЗӨБЦТС” ХК-ийн шугамын ачаалал өмнөх 3 өдрийн тухайн цагт авч байсан ачааллын дунджаас 30% -иас нэмэгдсэн буюу хасагдсан эсвэл бүр ачаалалгүй болсон

тохиолдолд “БЗӨБЦТС” ХК болон Дундговь ЦТССалбарын диспетчерт мэдэгдэж, тухайн шалтгааныг тодруулна.

5.8 Системийн хэмжээнд чадлын дутагдалд орж, хэрэглэгчдийг ЦЭХ-ээр хязгаарлах үед батлагдсан таслалт хязгаарлалтын графикайн дагуу хэрэглэгчдийг хязгаарлаж таслана. “ЦДҮС”-ХК-ийн Говийн Бүсийн Салбарын харьяа дэд станцын диспетчер нь хязгаарлалт хийсний дараа, хүчдэл залгахын өмнө “БЗӨБЦТС” ХК-ийн диспетчерт мэдэгдэж хэвийн ажиллагааг сэргээх ба схем бүрэн сэргээсний дараа хэрэглэгч бүрэн залгагдаж ачаалал авч эхэлсэн эсэхийг БЗӨБЦТС ХК-ийн диспетчерт мэдээлэл өгөх бө хязгаарлалтын шалтгаан, тухайн шугамын параметрууд, тасалсан залгасан цагийг харилцан тохиролцсон байна. Хязгаарлалт хийгээд буцааж хүчдэл өгөхийн өмнө БЗӨБЦТС ХК-ийн диспетчерт заавал мэдэгдэж, залгах үйлдэл хийнэ.

5.9 ДҮТ ХК-аас хязгаарлалт хийх талаар урьдчилан мэдэгдсэн тохиолдолд БЗӨБЦТС ХК-ийн диспетчерт мэдэгдэж, зарлал хийлгэсэн байна.

5.10 Нэгдсэн сүлжээний өвлийн их ачаалал болон зуны бага ачааллын горим ажиллагааны үед Эрчим Хүчний Систем чадлын дутагдалд орсноос буюу болзошгүй аваарийн үед тасалж хязгаарлах шугам, хэрэглэгчдийн графикайг хоёр байгууллагын шуурхай ажиллагааны удирдлагууд жил бүр өвөл, зуны горим ажиллагааны үед хамтарч гарган ерөнхий инженерээр батлуулан байнга мөрдөж ажиллана.

5.11 Эрчим хүчний систем чадлын дутагдалд орсноос болж АЧР-ээр ачаалал хөнгөлөх шугам, тоноглолын жагсаалтыг хоёр байгууллагын РХА-ын инженерүүд хамтран гаргаж ерөнхий инженерүүдээрээ батлуулан, байнга мөрдөж хяналт тавьж ажиллана.

5.12 Эрчим хүчний систем чадлын дутагдалд орсон болон аваари саатлын үед системийн тогтвортой ажиллагааг хангах зорилгоор зайлшгүй хязгаарлалт хийх болж байгааг ЦДҮС ХК-ийн Говийн Бүсийн Салбарын диспетчерүүд нь БЗӨБЦТС ХК-ийн диспетчерүүдэд аль болохоор урьдчилан мэдэгдэж байна.

5.13 Хязгаарлалтаар таслагдсан чадлын хэмжээ, тасалсан залгасан цаг хугацаа, дутуу түгээсэн цахилгаан эрчим хүчийг хоёр талын диспетчер тулгалт хийж, таслалт хязгаарлалтыг бүртгэх журналд бүртгэнэ.

### ***Зургаа: Наряд шийдвэрээр бригадыг ажилд оруулах***

6.1 Захиалгат ажлуудыг гүйцэтгэхдээ хоёр тал өөрсдийн аюулгүй ажиллагааны наряд, шийдвэрээр гүйцэтгэнэ. Аюулгүй ажиллагаа хариуцагч нар нь тушаалаар томилогдсон байна.

6.2 Батлагдсан захиалгын дагуу ажилд орохдоо засварын хүмүүс нь өөрсдийн диспетчерт ажлын нарядыг танилцуулна. Тухайн диспетчер ажлын нарядыг хянаад ямар нэг зөрчилгүй, зөв гэж үзсэн тохиолдолд нөгөө талын диспетчерт хийх ажлын утга агуулга, авах техникийн арга хэмжээг харилцан тохирч ажлын байр бэлтгүүлнэ.

6.3 Хоёр байгууллагын диспетчерүүд ажлын байр бэлдэх явцад ямар нэгэн эргэлзээ төрвөл ажлын байр бэлтгэх ажиллагааг зогсоож, нөгөө талын диспетчертээ мэдэгдэнэ.



6.4 БЗӨБЦТС ХК болон “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбарын диспетчерүүд нь ажлын байр хэрхэн бэлтгэсэн тухайгаа харилцан мэдэгдэнэ. “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбар болон БЗӨБЦТС ХК-ийн ажилд оруулагч, ажлын удирдагч, ажил гүйцэтгэгч нар БЗӨБЦТС ХК болон “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбарын диспетчерүүдийн бэлтгэсэн ажлын байрыг газар дээр нь ирж шалгаж хүлээж авна. Ажилд оруулахдаа заавал хүчдэлгүй болсныг шалгавал зохино.

6.5 “ЦДҮС”-ХК-ийн Говийн Бүсийн Салбарын шуурхай ажиллагааны хүмүүс нь өөрийн эзэмшлийн цахилгаан байгууламжинд “БЗӨБЦТС” ХК-ийн ажилтан орж ажил гүйцэтгэх үед нэмэлт тухайлсан зааварчилгаа, санамжийг өгч болно

6.6 “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбарын болон “БЗӨБЦТС” ХК-ийн диспетчерүүд нь өөрсдийн эзэмшлийн болон уг зааврын 2.11-д дурьдсан хэрэглэгчийн эзэмшлийн тоноглолд хийгдсэн сэлгэн залгалт, наряданд заагдсан техникийн арга хэмжээг ААД-ийн 2.1-2.7, 3-р бүлэгт заасны дагуу бүрэн, үнэн зөв гүйцэтгэсэн хариуцлагыг тус тусдаа бүрэн хүлээнэ.

6.7 Засварын бригад нь наряданд заагдсан ажлыг хийж гүйцэтгэж дууссан тухай мэдээллийг ажлын удирдагч, ажил гүйцэтгэгч нь өөрсдийн диспетчерт мэдэгдэнэ.

6.8 БЗӨБЦТС ХК-ний диспетчер нь нарыдаар хийгдсэн ажил бүрэн дуусаж, цахилгаан байгууламжийг хүчдэлд залгах бололцоотой болсон тухай мэдээллийг “ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбарын диспетчерт өгнө

6.9 “ЦДҮС”-ХК-ийн Говийн Бүсийн Салбарын диспетчер нь БЗӨБЦТС ХК-ийн диспетчерийн мэдээллийн дагуу ажлын байр хурааж, хүчдэл залгахын өмнө БЗӨБЦТС ХК-ийн диспетчерт анхааруулж, хүчдэл залгасны дараа хариу мэдээлэл хийнэ.

6.10 Батлагдсан захиалгын дагуу ажлын байр бэлтгэхэд нарийн төвөгтэй, олон ажилбартай сэлгэн залгалт хийгдэхээр мөн түүнчлэн ажлын наряд урьд өдөр нь танилцуулагдсан байвал хоёр талын диспетчерүүд тохирон ажлын байрыг урьдчилан бэлтгэж болно. Урьдчилан ажлын байр бэлтгэхдээ хоёр талын шуурхай ажиллагааны дээд шатны удирдлагын зөвшөөрөл авна.

6.11 Хоёр байгууллагын шуурхай ажиллагааны хүмүүсийн зөрчил, алдааны улмаас ажлын байр бэлтгэх болон хураах, ажилд оруулах үйл явц хойшлогдох, захиалгын хугацаа хэтрэх, сэлгэн залгалтыг үргэлжлүүлэх боломжгүй, зогсоход хүрсэн тохиолдолд хоёр талын хамтарсан комисс хэн буруутай этгээдийг тогтоож хариуцлага хүлээлгэнэ.

***Долоо: Тасралт, таслалт, төлбөртэй үйлчилгээг бүртгэж баталгаажуулах***

7.1. ЦДҮС” ХК-ийн Говийн Бүсийн Салбар болон “БЗӨБЦТС” ХК нь тухайн сар хийгдсэн таслалт, залгалт, тасралтын тоог бүртгэл хийж баталгаажуулна

7.2. Таслалтыг төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус гэж 2 ангилна. ***Үүнд:***

7.2.1. Төлөвлөгөөт таслалтанд 2 талын хамтран тохиролцсон тухайн сарын таслалтын графикт орж батлагдсан ажлуудыг хийх таслалт орно.

7.2.2. Төлөвлөгөөт бус таслалтын ажлууд гэдэгт батлагдсан графикайн дагуу хийгдэх их болон урсгал засварын, аянгын улирлын өмнөх бэлтгэл ажлаас бусад бүх төрлийн ажлууд орно.Үүнд:

- » Аваарийн захиалгаар хийгдэх таслалт
- » Шугам тоноглол хамгаалалтаар тасраад АПВ цикл оролцуулаад 4 дэхь залгалтаас эхлэн хийгдсэн залгалт, таслалт
- » Шинээр шугам тоноглол холбохоор хийгдсэн залгалт, таслалт
- » Таслалтын графикт ороогүй боловч захиалгаар хийгдсэн ажил
- » ЦЭХ-ний төлбөр төлөөгүй хэрэглэгчийг хязгаарлах таслалт
- » Таслалтын графикийг дээрхи заасан хугацаанд өгөөгүй тохиолдолд тухайн сард хийгдсэн таслалтууд орно

7.3. Таслалт залгалтын мөнгийг дараах нөхцөлүүдэд тооцохгүй.Үүнд:

- » Дэд станцын шинэнд гарсан газардлага хайх зорилгоор хийх таслалт,залгалт
- » АТП болон КТПН-ийн хуурай салгуур,шугамын перемычка холболтууд тасарсан үед хийгдэх таслалт залгалт
- » Трансформаторын дэд өртөөний хүчний трансформаторт болон 0.4кВ талд гал гарсан нөхцөлд мөн богино залгааны гүйдлээс болж таслах залгах коммутацийн аппаратаар үйлдэл хийх боломжгүй болсон үед хийгдэх таслалт залгалт

7.4. Тухайн сард төлөвлөгөөт бус таслалтаар хийгдсэн таслалтын бүртгэлийг хоёр байгууллагын ашиглалтын инженерүүд сар бүрийн эцэст нэгтгэн дараа сарын 5-ны дотор дутуу түгээсэн цахилгаан эрчим хүчний тооцоог нийлж хоёр байгууллагын ерөнхий инженерээр баталгаажуулна.

**“ЦДҮС” ТӨХК-ийн Говийн Бүсийн Салбарын дэд станцуудын шинээс гарч байгаа “БЗӨБЦТС”ТӨХК-ийн шугам тоноглолын тогтоосон эзэмшлийн зааг**

**1. ЦДҮС ХК-ийн Говийн Бүсийн салбарын эзэмшилд:**

- » 110/35/10кВ-ын МГ дэд станцын Чойр-МГ 110кВ-ын ЦДАШ-ын төгсгөлийн буултын утсаар МГ дэд станцын бүх тоноглол
- » 110/35/10кВ МГ дэд станцын Олгойнговь, Төв, Луус, Гурвансайхан 35кВ-ын шугамын салгууруудын шугам талын холболтын боолтоор

**2. ЦДҮС ХК-ийн Зүүн Өмнөд Бүсийн салбарын эзэмшилд:**

- » 220/110/35/6кВ Чойр дэд станцаас гарсан Чойр- МГ 110кВ ЦДАШ, МГ 110кВ-ын шугам болон шинийн таслуурууд

**3. БЗӨБЦТС ХК-ийн эзэмшилд:**

- » Олгойнговь, Төв, Луус, Гурвансайхан 35кВ-ын дэд станц, 35кВ-ын ЦДАШ

**Жич: ТЗЭ болон хувийн эзэмшигчийн шугам тоноглолд хийгдэх ажлын захиалга болон шуурхай ажиллагааг БЗӨБЦТС”ТӨХК-ийн диспетчерээр дамжуулан явуулна.**